



I/2022

Тархаасан: 2022 оны 3 дугаар сарын 14



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2022 оны 1 дүгээр сард өмнөх сараас 10.1 хувиар буурсан байна


Гадаад худалдааны нөхцөлийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2022 оны 1 дүгээр сард 167.0 болж, өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар өссөн байна.

Харин өмнөх сараас 10.1 хувиар буурсан байна. Энэ нь импортын үнийн индекс өмнөх сараас 4.0 хувь, экспортынх 13.7 хувиар буурснаас шалтгаалжээ.

Экспортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2022 оны 1 дүгээр сард 186.8 болж, экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 26.2 хувиар өссөн байна. Харин өмнөх сараас 13.7 хувиар буурсан байна. Экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 26.2 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 35.3 хувиар (зэсийн баяжмал, чулуун нүүрс, түүхий нефть) өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин өмнөх сараас 13.7 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 27.8 хувиар (төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал) буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Импортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2022 оны 1 дүгээр сард 111.9 болж, импортын үнэ өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар өссөн байна. Харин өмнөх сараас 4.0 хувиар буурсан байна. Импортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 44.3 хувиар (нефть, цахилгаан эрчим хүч) өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин өмнөх сараас 4.0 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 2.8 хувь (нефть), тээврийн хэрэгслийн бүлгийн үнэ 10.2 хувиар (суудлын машин) буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 1. ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛИЙН ИНДЕКС¹ (2015=100), хувь



¹ Туршилт тооцоо

Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индексийг экспортын үнийн ерөнхий индексийг импортын үнийн ерөнхий индексэд харьцуулж тооцно.

Экспортын үнийн индекс: Монгол Улсын экспортын голлох худалдааны түнш орнуудад нийлүүлж буй барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

Импортын үнийн индекс: Монгол Улсын худалдааны түнш орнуудаас импортолж буй гол нэрийн барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.



Суурь үе: Индекс тооцоход хугацааны бусад үеийн үзүүлэлтэд харьцуулж тооцох хугацаа юм.

Эх үүсвэр:

Гаалийн Ерөнхий Газар

Ангилал:

Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 4 дүгээр сарын 13

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Д.Мөнхтуул
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212